



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2007 оны 1 сарын 24 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

**Хотын ногоон байгууламжийн сан  
байгуулах тухай**

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.18.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.4, 79 дэх заалтыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

Нэг. Нийслэл хотын ногоон байгууламжийг хөгжүүлэх, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, парк, цэцэрлэг байгуулах, гэр хорооллыг ойжуулах, агаарын бохирдлыг бууруулахад хөрөнгө төвлөрүүлэх зорилго бүхий Хотын ногоон байгууламжийн санг байгуулж, дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Ногоон байгууламжийн сангийн зорилго, ач холбогдлыг сурталчлах, санд хөрөнгө төвлөрүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг ~~2007 оны 2 дугаар улиралд~~ багтаан шийдвэрлэж, хэрэгжүүлэхийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Ц.Батбаяр/-д үүрэг болгосугай.



*Ц.Батбаяр*

Н.БОЛОРМАА

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2007 оны 1.9 дүгээр  
тогтоолын хавсралт

## **НОГООН БАЙГУУЛАМЖИЙН САНГИЙН ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 “Ногоон байгууламжийн сан” /цаашид “сан” гэх/-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнахад энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.2 Сан нь хотын ногоон байгууламжийг хөгжүүлэх, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, парк, цэцэрлэг байгуулах, гэр хорооллыг ойжуулах, агаарын бохирдлыг бууруулах, экологийг сайжруулах арга хэмжээг санхүүжүүлэх болон тэдгээрт дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

1.3 Сан нь хотын төсвийн бүрэлдүүн хэсэг болж сангийн орлого, зарлага нь жил бүрийн төсвийн төсөл, төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тайланд тусгана.

### **Хоёр. Сангийн эх үүсвэр, түүнийг төлөвлөх, бүрдүүлэх**

2.1 Сангийн хөрөнгө дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

- 2.1.1 Ногоон байгууламжийн арчилгаа, цэцэрлэгжилтэнд зориулан төсвөөс хуваарилагдсан хөрөнгө.
- 2.1.2 Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг санхүүжүүлэх арга хэмжээний зохих хэсэг.
- 2.1.3 Хандивлагчид, олон улсын байгууллагын болон гадаад орны буцалтгүй тусламж, хандив.
- 2.1.4 Байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийн хандив.
- 2.1.5 Хотын ногоон байгууламж, эд аж ахуйд учруулсан хохирлын орлого.
- 2.1.6 Шинээр баригдаж буй барилгын тохижилт хийх, ногоон байгууламжийг үүсгэх зардлыг төсөвт өртгөөс нь урьдчилан төвлөрүүлэх хэлбэрээр авсан орлого.
- 2.1.7 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

### **Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт**

3.1 Сангийн хөрөнгийг дор дурдсан зориулалтаар зарцуулна:

- 3.1.1 Хот, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа, тордолгоо хийх.
- 3.1.2 Хотын гудамж, талбайг шинээр цэцэрлэгжүүлэх, хот, дүүргийн чанартай парк, цэцэрлэг болон бичил цэцэрлэг байгуулах.
- 3.1.3 Хотыг шинээр болон нөхөн зүлэгжүүлэх, цэцгийн мандал байгуулах, цэцгийн ваар, сав үйлдвэрлэх.
- 3.1.4 Хотын ногоон байгууламжинд илэрсэн өвчин, хортонг устгах, мод, сөөгийг эрүүлжүүлэх.

- 3.1.5 Хот, нийтийн гудамж, талбай, гэр хорооллыг ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажлыг урамшуулах.
- 3.1.6 Гадаад, дотоодоос чухал шаардлагатай мод, сөөг, цэцэг, зүлэгний үр үрслүүр худалдан авах, нутагшуулах.
- 3.1.7 Хот цэцэрлэгжилтийн ажилд онцгой хувь нэмэр оруулсан иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг урамшуулах, цэцэрлэгжилт, ногоон байгууламжийн чиглэлээр ном товхимол хэвлүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах, санал солилцох, онол практикийн бага хурал зохион байгуулах зэрэг арга хэмжээг санхүүжүүлэх.
- 3.1.8 Хотын ногоон байгууламжийг услах услалтын систем, хайс хашлага хийх, худаг гаргах, усан оргилуур байгуулах.

#### **Дөрөв. Сангийн удирдлага**

4.1 Сан нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дэргэд байх бөгөөд Хотын ерөнхий менежерийн удирдлагын дор ажиллана.

4.2 Тухайн жилд санд хуримтлагдах орлогын эх үүсвэр, сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ болон зарцуулалтын хуваарийг Нийслэл Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч батална.

4.3 Санд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс хандив, тусламж төвлөрүүлэх ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны Хот нийтийн аж ахуйн хэлтэс зохион байгуулна.

4.4 Сангийн хөрөнгийг төрийн тусгай дансанд байршуулах бөгөөд сангийн санхүүг ЗАА-ны Хот нийтийн аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч давхар хариуцна.

4.5 Сангийн хөрөнгийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн дагуу зарцуулж, үр дүнг тайлагнана.

#### **Тав. Хариуцлага**

5.1 Сангийн хөрөнгийг бусдад хандивлах, барьцаалах, зээлээр ашиглуулах буюу дүрэмд зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

5.2 Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, шамшигдуулсан буруутай этгээд, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.